



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А154

Мандалговь

Г С.Чинбатад дэмжлэг олгох тухай Г

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.7, Монголын мэргэшсэн Нягтлан бодогчдын институт-ын гүйцэтгэх захирлын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 6/363 дугаар тоот албан бичиг, "Байгууллагын дотоод журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2, дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Нягтлан бодогч С.Чинбат нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, мэргэшсэн Нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм, ДНБХ-ны боловсролын Олон Улсын стандартын дагуу Мэргэшсэн нягтлан бодогчдын тасралтгүй боловсролын сургалтын зардал 135000 (Нэг зуун гучин таван мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 135000 (Нэг зуун гучин таван мянга) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын хугацаанд идэвхи санаачлагатай хамрагдаж, тайланг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж ажиллахыг Нягтлан бодогч (С.Чинбат)-д үүрэг болгосугай

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190-15